



# МОНГОЛ УЛСЫН ШИНЖЛЭХ УХААНЫ АКАДЕМИЙН ЕРӨНХИЙЛӨГЧИЙН АЛБАН ДААЛГАВАР

2018 оны 02 дугаар  
сарын 16 өдөр

Дугаар 1/77

Улаанбаатар хот

## Хөдөлмөрийн бүтээмж, сахилга хариуцлагыг сайжруулах зарим арга хэмжээний тухай

“Сахилга хариуцлага, дэг журмыг чангатгах тухай” Монгол Улсын Засгийн газрын 2017 оны 01 тоот албан даалгавар, “Албан даалгаврын хэрэгжилтийг хангах тухай” БСШУС-ын сайд Ц.Цогзолмаагийн 2017 оны А/288 тоот тушаалыг хэрэгжүүлэх зорилгоор Монгол Улсын Засгийн газраас 2018 оныг хариуцлагын жил болгон зарласантай холбогдуулан харьяа хүрээлэнгийн захирал нарт дараах албан даалгаврыг өгч байна:

### 1. Хүний нөөцийн чадавхийг дээшлүүлэх:

Нийт эрдэм шинжилгээний ажилтны дотор шинжлэх ухааны докторын эзлэх хэмжээг харьяа хүрээлэнгүүдийн дунджаар 2020 онд 8 хувь, 2024 онд 11 хувьд хүргэх, ойрын 2 жилд багтаан хүрээлэнгийн үндсэн бүтцийн нэгж бүрийг доктор, шинжлэх ухааны докторын зэрэгтэй хоёроос доошгүй ажилтантай болгох, эрдэм шинжилгээний ажилтны гадаад хэлний мэдлэгийг эрс дээшлүүлэх талаар бодитой ажил зохион байгуулах, хүрээлэнд 12 болон түүнээс дээш жил ажиллахдаа докторын зэрэг хамгаалаагүй эрдэм шинжилгээний ажилтнуудад 2-3 жилийн дотор докторын зэрэг хамгаалах талаар хугацаа, болзолтой даалгавар өгөх, бакалаврын зэрэгтэй ажилтны тоог 2021 он гэхэд 2017 оны түвшнээс 2 дахин бууруулсан байх зэрэг үйл ажиллагааг хэрэгжүүлэх замаар хүний нөөцийн чадавх, хөдөлмөрийн бүтээмжийг нэмэгдүүлэх зорилт тавин ажиллах;

### 2. Төрийн өмчийн байр, өмч хөрөнгийн ашиглалтыг сайжруулах:

2018 оны эхний улиралд багтаан ШУА-ийн баланст байгаа барилга байгууламжийн үзлэг явуулж, ашиглалтгүй, зориулалтын бусаар ашиглаж байгаа өрөө тасалгааны тоо, хэмжээг гаргах, тэдгээрийг дахин хуваарилах санал боловсруулж хэрэгжүүлэх, олон жил ашиглагдаагүй байгаа хөрөнгийн тооллого дахин явуулж, ашиглах эсэхийг хуулийн хүрээнд шийдвэрлэн зай талбай чөлөөлж, ажилтан, албан хаагчдын ажиллах нөхцлийг сайжруулах, цахим мэдээллийн сан болон хүрээлэнгийн

вэб сайтыг байнга баяжуулж мэдээллийн хангамжийг шинэ шатанд гаргах;

**3. Ажлын цаг ашиглалтын нягтралыг нэмэгдүүлж, үр ашгийг дээшлүүлэх:**

Ажилтан, албан хаагчдын ирц, ажлын цагийн ашиглалт ба нягтралыг сайжруулах, сар бүр нийт ЭША-ны 10-аас доошгүй хувийг хамарсан ажлын цаг ашиглалтын хронометраж хийх, ажлын байрны дэг журмыг чанд сахиулах зэрэг арга хэмжээ авч ажлын үр ашгийг дээшлүүлэх;

**4. Ажлын хариуцлага, хөдөлмөрийн сахилгыг чангатгах:**

Хүрээлэнгийн үйл ажиллагаанд хөдөлмөрийн хууль тогтоомж, байгууллагын дотоод журмын хэрэгжилтийг хангах, гэрээний сахилга, төлөвлөгөөний гүйцэтгэлийн хариуцлагыг сайжруулах чиглэлээр тодорхой ажил зохион байгуулах, ажиллагсадын ажлын төлөвлөгөөний биелэлтийг хагас, бүтэн жилээр А, В, С, D, F системийн үнэлгээгээр дүгнэж хэвших;

**5. Хүрээлэнг хөгжүүлэх дунд хугацааны стратеги төлөвлөгөөний хэрэгжилтийг эрчимжүүлэх:**

Хүний нөөц, хөрөнгө оруулалт, гадаад хамтын ажиллагааны боломж, цаашдын хөгжлийн чиг хандлагыг харгалзан хүрээлэнгийн судалгааны 3 хүртэлх үндсэн чиглэл тогтоох, ойрын 3 жилд нийлүүлэх бололцоотой тусгай захиалгат 6-аас доошгүй бүтээгдэхүүний шинжлэх ухааны үндэслэл ба түвшин, хамрах, нөлөөлөх хүрээ, урьдчилсан ТЭЗГооцоо, ТЭЗҮ-ийг тодорхойлох, санхүүгийн чадавхаа стратеги төлөвлөгөөтэй уялдуулж, дунд хугацааны төсвийн төслийг төлөвлөж тайлбарын хамт дээд шатны байгууллагадаа ирүүлж хэвших;

Энэхүү албан даалгаврын биелэлтийг 2018-2020 онд тухайн оны улирал бүрийн сүүлийн сарын 20-ны дотор илтгэх хуудсаар гарган, өөрийн биеэр Шинжлэх ухааны Академид мэдээлж байхыг хүрээлэнгийн захирал нарт үүгээр үүрэг болгож байна.

ЕРӨНХИЙЛӨГЧ, АКАДЕМИЧ



Д.РЭГДЭЛ